



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Нислэгийн шугамыг хуваарилах, агаарын
тээвэрлэгчийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар-Бусан-Улаанбаатар олон улсын нислэгийн чиглэлийг агаарын тээврийн "МИАТ" ТӨХК-д хуваарилж, нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилсугай.

2. Дээрхи нислэгийн чиглэлд агаарын тээврийн "МИАТ" ТӨХК-ийг томилж байгаа талаар Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасанд даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "МИАТ" ТӨХК-д нислэг үйлдэхэд шаардагдах бэлтгэлийг хангах, нислэгийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ